

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлбар тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Бичиг Баримт
ХХЕГ	Хил Хамгаалах Ерөнхий Газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГЫН
АЛБАНЫ ЗАХИРАЛ Д.ОЮУНГЭРЭЛ
ТАНАА

2020.03.13 № 06/879
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийндагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1. Аудитын гэрчилгээ

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГЫН АЛБАНЫ
ЗАХИРАЛ Д.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийндагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг албаны захирал Д.Оюунгэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулгазэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны онцлогийг тусгасан зүйл заалтуудыг нэмж оруулах, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ноос 2020 оны 03 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албанд хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар "Релаэнс секюритиз аудит" ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, аудитор Д.Эрдэнэбаяр, аудиторын туслах Г.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь үйл ажиллагааны зорилгоо "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хил хамгаалах байгууллагатай холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжүүдийг төлөвлөх, батлуулах, батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч байгууллагуудыг сонгон шалгаруулж, ажлын явцад нь захиалагчийн хяналт тавьж, хугацаанд нь ашиглалтанд оруулах, хөрөнгө гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг олгох" гэж тодорхойлсон.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба үйл ажиллагааны чиглэлээ Хил хамгаалах байгууллагын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ, байгууллагын өөрийн хөрөнгөөр баригдах барилга, машин тоног төхөөрөмж, цахилгаан холбооны шугам сүлжээ, инженерийн хийцтэй авто зам, гүүр, далан суваг, уст цэг, хилийн инженерийн байгууламж, тэдгээрийн их засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажилд холбогдох мэргэжлийн хэлтэс, албадын саналыг тусгаж, техникийн нөхцлийг бүрдүүлэн зураг төсөл захиалж хийлгэх, гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийхээр тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот "Журам батлах тухай" тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот "Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол

2.5 Нягтан бодох бүртгэлийн бодлого санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь Хил хамгаалах байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй байна.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа санхүүгийн "Лидер" программ хангамжийг ашигладаг байна.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд 6 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дүн 1,988.4 сая төгрөгөөс тооцон 39.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дүн 498.1 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 9.9 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,399.1 сая төгрөгөөр буюу 86.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	356.6	768.1	411.5
Авлага	0.7	25.0	24.3
Урьдчилгаа	5,844.2	2.0	(5,842.2)
Бараа материал	0.4	0.7	0.3
Үндсэн хөрөнгө	11.2	18.2	7.0
Нийт хөрөнгө	6,213.1	814.0	(5,399.1)
Өр төлбөр	6,117.1	579.5	(5,537.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	96,0	234.5	138.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,213,1	814,0	(5,399.1)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 24.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Хилийн 0119 дүгээр ангиас авах 25.0 сая төгрөгийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 2.0 сая төгрөг нь Хилийн 0245, 0214 дүгээр ангиудын 2020 онд хийх орон сууцын барилгуудын их засварын зураг төсвийн урьдчилгаа төлбөр болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7.0 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээгээр нэмэгдсэн 7.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тайлант онд худалдаж авсан 1.7 сая төгрөгийн тавилга эд хогшил зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,537.6 сая төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн 5,972.9 сая төгрөгийн Хууль зүй дотоод хэргийн яамны конторын барилгын ажлын төлбөрийг тайлант онд гүйцэтгэлээр борлуулалтын орлого дансанд бүртгэсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр данс 544.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст төлөх татварын өр 35.4 сая төгрөг, барилгын ажлын гүйцэтгэгч "Дабль пирамид" ХХК-д өгөх Хууль зүй дотоод хэргийн салбарын нэгдсэн конторын барилгын барьцаа болох 400.0 сая төгрөгийн өглөг, "Дабль пирамид" ХХК-д өгөх Хууль зүй дотоод хэргийн салбарын нэгдсэн конторын барилгын магадлашгүй ажлын зардал 144.1 сая төгрөг тус тус байна. Дээрх өр төлбөрүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлбар тодруулга

ХХЕГ-ын дарга, Хилийн цэргийн командлагч, /ерөнхий менежер/-тэй ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт барилгын алба нь Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 2019/03 тоот гэрээгээр баталсан байна.

Хүснэгт 2. Орлогын үр дүнгийн тайлан

Үзүүлэлтүүд	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	455.5	498.1	42.6	109.3
Ерөнхий удирдлагын зардал	393.4	352.9	40.5	89.7
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	62.2	145.2	83.0	233.4
Орлогын татварын зардал	6.2	14.5	8.3	233.9
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	56.0	130.7	74.7	233.4
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	56.0	130.7	74.7	233.4

Тайлант онд ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь 498.1 сая төгрөгийн барилга, хяналтын ажлыг хийж борлуулалтын орлогоо төлөвлөснөөс 42.6 сая төгрөгөөр давуулж биелүүлсэн.

Ерөнхий удирдлагын зардалд 352.9 сая төгрөг зарцуулж, шатахуун, албан томилолт, бичиг хэрэгсэл, багаж хэрэгслийн зардлаас 40.5 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Тайлант үеийн цэвэр ашиг төлөвлөснөөс 74.7 сая төгрөгөөр өссөн нь орлогыг 43.1 сая төгрөгөөр давуулж, зардлыг 40.5 сая төгрөгийг хэмнэснээс шалтгаалжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл тодорхойлж 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,134.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12,132.8 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 2.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Хууль зүй дотоод хэргийн яамны нэгдсэн конторын барилгын 12,132.8 сая төгрөгийн санхүүжилтийг хоорондын тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй, борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар

залруулна” гэсэн заалтын дагуу Хууль зүй дотоод хэргийн яамны барилгын ажлын гүйцэтгэл 12,132.8 сая төгрөгийг эх үүсвэрээр нь ангилан бүртгэж мөнгөн гүйлгээний тайланд тусгуулан харуулж, санхүүгийн тайланг залруулсан.

Аудитаар илэрсэн 2.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хууль зүй дотоод хэргийн яамны нэгдсэн конторын барилгын санхүүжилтийн эх үүсвэрт 8,000.0 сая төгрөгийг Монгол банкнаас авч зарцуулсан асуудлыг дараагийн аудитаар судалж, авч үзэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 324 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

И-баримтаар баталгаажаагүй 2.0 сая төгрөгийн зардлын баримт байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид бараа материалыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авахдаа и-баримт авч байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Хөрөнгө оруулалт, барилгын алба нь Хил хамгаалах байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохироогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль журмыг мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагынхаа онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	356,657,323.42	768,085,034.51
1.1.2	Дансны авлага	0.00	25,000,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	688,521.26	0.00
1.1.6	Бараа материал	403,357.81	767,259.56
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	5,844,191,600.00	2,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,201,940,802.49	795,852,294.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,167,791.53	18,187,213.77
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,167,791.53	18,187,213.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,213,108,594.02	814,039,507.84
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	0.00	544,141,785.00
2.1.1.3	Татварын өр	50,001.50	35,410,568.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,117,067,926.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,117,117,927.50	579,552,353.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,117,117,927.50	579,552,353.00
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	2,478,826.56	2,478,826.56
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	7,830,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	93,511,839.96	224,178,328.28
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	95,990,666.52	234,487,154.84
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	6,213,108,594.02	814,039,507.84

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,935,385,091.82	498,104,398.57
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	1,935,385,091.82	498,104,398.57
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	52,984,143.87	9,960,090.40
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,994,104,392.91	362,829,301.95
11	Санхүүгийн зардал	27,300.00	50,200.00
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(5,762,457.22)	145,184,987.02
19	Орлогын татварын зардал		14,518,498.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,762,457.22)	130,666,488.32
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,762,457.22)	130,666,488.32
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(5,762,457.22)	130,666,488.32
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,268,756,006.83	5,011,792,684.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,128,923,601.00	302,544,810.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,139,832,405.83	4,709,247,874.00
1.2	Мөнгөн зарлага (-)	8,042,423,197.99	4,608,625,063.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	61,538,857.00	94,445,424.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,491,319.83	6,691,378.10
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,097,665.00	1,041,950.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0	0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	673,516.00	1,066,100.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	25,607,831.16	22,767,118.57
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0	0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,950,014,009.00	4,482,613,092.64
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	226,332,808.84	403,167,620.69
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	52,984,143.87	9,960,090.40
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	52,984,143.87	9,960,090.40
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,170,000.00	1,700,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,170,000.00	1,700,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,814,143.87	8,260,090.40
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	271,146,952.71	411,427,711.09
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	85,510,370.71	356,657,323.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	356,657,323.42	768,085,034.51

4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,478,826.56		99,274,297.18	101,753,123.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл				-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			(5,762,457.22)	(5,762,457.22)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,478,826.56	-	93,511,839.96	95,990,666.52
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	Залруулсан үлдэгдэл				-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			130,666,488.32	130,666,488.32
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт				-
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		7,830,000.00		7,830,000.00
17	2019 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,478,826.56	7,830,000.00	224,178,328.28	234,487,154.84

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.06	Аудитын нэр:	ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын албаны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/99/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	ХХЕГ-ын Хөрөнгө оруулалт, барилгын алба	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	И-баримтаар баталгаажаагүй 2.0 сая төгрөгийн зардлын баримт байна.	2.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Цэенханд
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Цэенханд
	Нийтдүн	2.0			

